



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Оны тэргүүний тасаг, нэгж,
алба, баг, комисс, ажилтан
шалгаруулж шагнах тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын Гурвын 3.3, 3.4 дэх хэсэг, ЦССҮТ-ийн Хөдөлмөрийн хамтын гэрээний 3.16 дахь хэсэг, Ерөнхий захирлын 2022 оны А/87 дугаар тушаалаар байгуулагдсан Комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын Үндэсний төвийн “Оны шилдэг ажилтан”-аар Сувилахуй, үйлчилгээний албаны Үйлчлэгч Н.Идэржавхлан, Донор зохион байгуулалтын тасгийн Их эмч Б.Ижилбаатар, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Мэдээллийн технологийн инженер Ч.Далайцэрэн нарыг шалгаруулж, цом, мөнгөн шагналаар, “Оны шилдэг тасаг, нэгж”-ээр Үйлдвэрлэлийн тасгийг шалгаруулж цом, өргөмжлөл, тасгийн эрхлэгч Б.Оргилыг мөнгөн шагналаар, “Оны шилдэг алба, баг, комисс”-оор Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шалгаруулж, өргөмжлөл, Зөвлөлийн дарга Ч.Батболдыг мөнгөн шагналаар, “Захирлын нэрэмжит шагнал”-аар Донор зохион байгуулалтын тасгийн Технологич сувилагч Д.Одмаа, Нэгдсэн лабораторийн тасгийн Лаборант Д.Сайра, Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч Д.Дуламсүрэн нарыг шагнаж, өргөмжлөл, мөнгөн шагналаар, “Чанарыг эрхэмлэгч ажилтан”-аар Нэгдсэн лабораторийн тасгийн Лаборант У.Янжиндулам, Донор зохион байгуулалтын тасгийн Технологич сувилагч Б.Буянтогтох нарыг тус тус шалгаруулж, мөнгөн шагналаар, “Чанарыг эрхэмлэгч талархалын хуудас”-аар Сувилахуй, үйлчилгээний албаны Ариутгагч Д.Бүдханд, Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч У.Пүрэвсүрэн, П.Цэндхүү, Донор зохион байгуулалтын тасгийн

Технологич сувилагч Н.Батцэрэн нарыг шалгаруулж, мөнгөн шагналаар тус тус шагнасугай.

2. Оны шилдэг тасаг, зөвлөл, ажилтнаар шалгарсан дээрх тасаг, зөвлөл, ажилтанд олгох мөнгөн шагналын хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Шагналын мөнгийг цалингийн зардлаас, өргөмжлөл, үнэ бүхий зүйлд зарцуулах хөрөнгийг бусад зардлаас гаргахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 4/3 дугаар тушаалын
хавсралт

ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТНУУДАД ОЛГОХ
МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Овог нэр	Шагналын хэмжээ
1	Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч	Б.Оргил	2.450.000
2	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга	Ч.Батболд	1.225.000
3	Сувилахуй, үйлчилгээний албаны Үйлчлэгч	Н.Идэржавхлан	1.000.000
4	Донор зохион байгуулалтын тасгийн Их эмч	Б.Ижилбаатар	1.000.000
5	Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Мэдээллийн технологийн инженер	Ч.Далайцэрэн	1.000.000
6	Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч	Д.Дуламсүрэн	800,000
7	Нэгдсэн лабораторийн тасгийн Лаборант	Д.Сайра	800,000
8	Донор зохион байгуулалтын тасгийн Технологич сувилагч	Д.Одмаа	800,000
9	Нэгдсэн лабораторийн тасгийн Лаборант	У.Янжиндулам	650.000
10	Донор зохион байгуулалтын тасгийн Технологич сувилагч	Б.Буянтогтох	650.000
11	Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч	П.Цэндхүү	650.000
12	Сувилахуй, үйлчилгээний албаны Ариутгагч	Д.Бүдханд	480.000
13	Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч	У.Пүрэвсүрэн	480.000
14	Донор зохион байгуулалтын тасгийн Технологич сувилагч	Н.Батцэрэн	480.000